



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 6 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 231


Улаанбаатар
хот

Төмөр замын суурь бүтцийн барилгын
ажлын зөвшөөрөл олгох тухай

Барилгын тухай хуулийн 32.1.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтцийн барилгын ажлын зөвшөөрлийг "Монголын төмөр зам" ТӨХК-д олгосугай.

2. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтцийн технологийн иж бүрдэл болох инженерийн байгууламж, эрчим хүч, усан хангамж, өртөө, зөрлөгийн болон дохиолол холбоо, мэдээллийн барилга байгууламжийг барихад шаардлагатай зөвшөөрлийг зохих журмын дагуу тухай бүр шуурхай олгож байхыг холбогдох сайд, Өмнөговь, Дорноговь аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Зам тээврийн хөгжлийн сайд

У.ХҮРЭЛСҮХ

Б.ЭНХ-АМГАЛАН